



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2024 оны 14 сарын 28 өдөр

Дугаар 57245

Улаанбаатар хот

**Э.Энхтуулд сахилгын шийтгэл  
ногдуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, 37.1.18, 39 дүгээр зүйлийн 39.1.18, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1.2 дахь заалт, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.7, 19 дүгээр зүйлийн 19.4.7 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны Б/1306 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын аюулгүй байдлыг хангах журам"-ын 4 дүгээр зүйл, 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.1, 10.4, 10.5, 10.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Эрдэнэхүүгийн Энхтуул нь хүний хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтэрч мэдээлэл цуглуулж, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг зөрчиж бүртгэл хөтөлсөн нь Хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2024 оны 1628 дугаар "Дүгнэлт", өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн нээлттэй сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандaa хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхтуулд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Д.Оюунбилэг/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-тус тус даалгасугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвэл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142401208